

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны.... дугаар
ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

сарын-

Тусгай зөвшөөрлийн нөхцөл,
шаардлага батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт, 9.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс дагаж мөрдсүгэй.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг баталсантай уялдуулан холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Тусгай зөвшөөрлийн газар (Х.Номинбилэг)-т үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

---- ГАРЫН ҮСЭГ-----

Эрчим хүчний зохицуулах хорооны
2025 оны сарын өдрийн
..... тогтоолын хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү нөхцөл, шаардлагын зорилго нь Эрчим хүчний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд тус тус заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага нь Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-12.11, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.23-14.33-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг сайжруулах, технологийн дагуу найдвартай, үр ашигтай ажиллах, хэрэглэгчийн эрх ашгийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн нөхцөл

Эрчим хүчний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-12.11, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 14.23-14.33 дахь заалтын дагуу үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран дараах нөхцөлүүдийг хангасан байна.

- 2.1. Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой, санхүүгийн чадавхтай;
- 2.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зориулалтын технологийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бүрдүүлсэн;
- 2.3. Мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг аюулгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах дадлага, туршлага бүхий, холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагад нийцсэн хүний нөөцийг бүрдүүлсэн байх;
- 2.4. Эрчим хүчний хэмнэлтийн бодлого, хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх боломжтой;
- 2.5. Үйлдвэрлэсэн, дамжуулсан, түгээсэн, хангасан эрчим хүчийг хэмжих баталгаажсан тоолуур, хэмжих хэрэгсэлтэй байх;
- 2.6. Техникийн алдагдал, горим тооцоо, борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээний программ хангамжууд, тайлагналын системтэй байх;
- 2.7. Үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах багаж хэрэгсэл, машин механизмтай байх;
- 2.8. Гарч болзошгүй аваар, ослоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, аюулгүйн нөөцийг бүрдүүлсэн байх;
- 2.9. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөртэй байх, тэдгээрийг хугацаанд нь хэрэгжүүлэх;
- 2.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан, эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх;

2.11. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааруулж, тусгай зөвшөөрлийн нөхцөлд хүчин чадал, үйлчлэх хүрээг тусгайлан тогтоох;

2.11.1. Эрчим хүчний барилга байгууламж барих, эрчим хүч үйлдвэрлэх, эрчим хүч дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөлд үндсэн тоноглол, түүний хүчин чадлын үзүүлэлтийг тусгасан байх;

2.11.2. Эрчим хүч түгээх, эрчим хүчээр зохицуулалттай болон зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөлд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчлэх хүрээг тусгасан байх. Үүнд:

Цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээг цахилгаан дамжуулах сүлжээнээс холбогдсон дэд станц, гаргалгааны дугаараар, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээг дулаан дамжуулах сүлжээнд холбогдсон салаа шугам, ус дулаан дамжуулах төвийн болон худгийн дугаар зэрэг мэдээллийг тусгана.

2.11.3. Эрчим хүчний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт зааснаар тусгай зөвшөөрөл олгосон нөхцөл өөрчлөгдөх, тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан бол тусгай зөвшөөрлийг шинэчлэх, эсвэл нэмэлт өөрчлөлт оруулахад дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

2.11.3.1. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээндээ хэрэглэгчийг шилжүүлэн авах тохиолдолд:

а. дундын эзэмшлийн 200 мм хүртэлх голчтой шугамын хамгийн их ачаалалтай тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн шугамд холбогдсон хэрэглэгч болон шинээр холбогдох хэрэглэгчийг;

б. өөрийн өмчлөл, эзэмшлийн ус дулаан дамжуулах төв, түгээх шугамаас дулаанаар хангагдсан хэрэглэгчийг үйлчлэх хүрээндээ шилжүүлэн авах;

в. шинэ хэрэглэгчийг үйлчлэх хүрээндээ авахад Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байх.

2.11.3.2. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнээс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд шилжүүлэх тохиолдолд:

а. дундын эзэмшлийн 200 мм хүртэл голчтой салаа шугамын хамгийн их ачаалалтай тусгай зөвшөөрөл эзэмшигчид өөрийн тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээний хэрэглэгчийг шилжүүлэх;

б. бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөл, эзэмшлийн ус, дулаан дамжуулах төв, түгээх сүлжээнээс холбогдсон өөрийн тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээний хэрэглэгчийг шилжүүлэх;

в. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй өөрийн тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээний хэрэглэгчийг шаардлага хангасан тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх;

г. өөрийн өмчлөл, эзэмшлийн 200 мм ба түүнээс дээш голчтой дулаан дамжуулах сүлжээг төрийн өмчид шилжүүлэн өгөх.

2.11.3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд дулааны хангамжийн сүлжээнд шинээр ус, дулаан дамжуулах төв, салаа шугам үүсгэн үйлчлэх хүрээндээ бүртгүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд хэрэглэгчийг шилжүүлж тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад Хорооны хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх ба тусгай зөвшөөрөл эзэмшигчийн

өөрийн өмчлөл, эзэмшлийн ус, дулаан дамжуулах төв, түгээх сүлжээнд шинээр холбогдох хэрэглэгчийг Хорооны даргын баталсан бүртгэлийн маягтын дагуу бүртгэнэ.

2.11.3.4. Эрчим хүч түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд хамаарах барилга байгууламж, хэрэглэгчийн мэдээллийг Эрчим хүчний зохицуулах хорооны тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан нэгж тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр бүртгэлийг хөтөлнө.

2.11.4. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

2.11.4.1. Тусгай зөвшөөрлийн хүчин чадалд нэмэлт, өөрчлөлт оруулахад:

- а. Хүсэлт гаргасан албан бичиг, тайлбар, тэдгээртэй холбоотой бусад нотлох баримтууд;
- б. Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт;
- в. Шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийн өртгийг бүртгэсэн балансын баримт бичиг;
- г. Өөрчлөлт оруулсны дараах техник, эдийн засгийн тооцоолол;
- д. Үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, техникийн нөхцөл, байршил, эзэмшлийн заагийн схем зураг, танилцуулга мэдээлэл;
- е. Холбогдох бусад баримт бичиг;

2.11.4.2. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад:

- а. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хүсэлт гаргасан албан бичиг, үйлчлэх хүрээндээ нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, тайлбар, тэдгээртэй холбоотой бусад нотлох баримтууд;
- б. Нэмэгдэх, өөрчлөгдөх барилга байгууламж, дамжуулах, түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн үзүүлэлт, техник, эдийн засгийн тооцоолол, техникийн нөхцөл, байршил, эзэмшлийн заагийн схем зураг, танилцуулга мэдээлэл;
- в. Тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт;
- г. Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.13 дахь заалтын дагуу нэмэгдэх, өөрчлөгдөх барилга байгууламжийн эрчим хүчний дэд станц, шугам тоног төхөөрөмжийг ашиглагч, өмчлөгч иргэн, хуулийн этгээдээс тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлсэн тухай хүсэлт, гэрээ, хүлээлгэн өгсөн акт, (нотариатаар гэрчлүүлсэн хувь) ;
- д. Тус барилга байгууламж нэмэгдэж өөрчлөгдсөнөөр техник, эдийн засгийн хувьд орох өөрчлөлтийн тооцоолол;
- е. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт хангагдаж байгааг нотлох баримт;
- ё. Холбогдох бусад баримт, бичиг;

Гурав. Тусгай зөвшөөрлийн шаардлага

Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд мөрдөж ажиллах шаардлагыг тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрээр дараах байдлаар тогтооно.

3.1. Цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шаардлага:

3.1.1. Цахилгаан үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, авар, сааталгүй ажиллах;

3.1.2. Диспетчерийн зохицуулалтыг мөрдөж, цахилгаан үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, стандартын шаардлага хангасан эрчим хүч үйлдвэрлэх;

3.1.3. Цахилгаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай, үр ашигтай явуулах;

3.1.4. Цахилгаан үйлдвэрлэх тоноглолын засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах;

3.1.5. Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах;

3.1.6. Үйлдвэрлэлийн барилга болон далангийн ашиглалт, аюулгүй байдал, усан сангийн ашиглалт, хамгаалалт, усны түвшин, голын урсац зэргийг багтаасан хяналт-шинжилгээний төлөвлөгөө, хөтөлбөр гаргаж, холбогдох байгууллагаар батлуулах;

3.1.7. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;

3.1.8. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах;

3.1.9. Санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах;

3.1.10. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.1.11. Татварын болон аудитлагдсан санхүүгийн тайлан, түүний тодруулгууд, холбогдох судалгаа, мэдээллийг үнэн зөв гаргаж хууль, дүрэм, журамд заасан хугацаанд тайлагнах, хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх бодит мэдээллийг шаардсан хугацаанд ирүүлэх;

3.1.12. “ДҮТ” ТӨХХК-тай байгуулсан цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг (төлбөр, тооцоо, алданги) улирал бүр дүгнэж, талууд акт үйлдсэн байх;

3.1.13. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн нэгдсэн сүлжээнд цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн нийлүүлж эхэлсэн өдрөөс хойш хөрөнгө оруулалтаа эргэн нөхөж буй гүйцэтгэлийн бодит мэдээллийг тарифт тооцсон үзүүлэлттэй харьцуулан ирүүлэх;

3.2. Дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шаардлага:

3.2.1. Дулаан үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах;

3.2.2. Үйлдвэрлэх дулааны эрчим хүчний горим, төлөвлөлтийг оновчтой төлөвлөж оны эхэнд баталсан төлөвлөгөөг мөрдөх, стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүч үйлдвэрлэх;

3.2.3. Дулаан үйлдвэрлэх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн найдвартай үр ашигтай явуулах;

3.2.4. Дулаан үйлдвэрлэх тоноглолын засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах;

3.2.5. Эрчим хүчний эх үүсгүүрээс байгаль орчинд хаях бохирдлыг холбогдох стандартаар тогтоосон хэмжээнд байлгах;

3.2.6. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;

- 3.2.7. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах;
- 3.2.8. Санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах;
- 3.2.9. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 3.2.10. Татварын болон аудитлагдсан санхүүгийн тайлан, түүний тодруулгууд, холбогдох судалгаа, мэдээллийг үнэн зөв гаргаж хууль, дүрэм, журамд заасан болон шаардсан хугацаанд ирүүлэх, тайлагнах;
- 3.2.11. Эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.3. Цахилгаан дамжуулах тусгай зөвшөөрлийн шаардлага:

- 3.3.1. Цахилгаан дамжуулах сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах;
- 3.3.2. Цахилгаан дамжуулах сүлжээний ашиглалт засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах;
- 3.3.3. Цахилгаан дамжуулах сүлжээний техникийн алдагдал болон дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний зарцуулалтыг тооцооны программ хангамж ашиглан улирал, жилээр тооцоолох, алдагдлыг бууруулах;
- 3.3.4. Цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангахад тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах;
- 3.3.5. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;
- 3.3.6. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах
- 3.3.7. Санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах;
- 3.3.8. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 3.3.9. Эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.4. Дулаан дамжуулах тусгай зөвшөөрлийн шаардлага:

- 3.4.1. Дулаан дамжуулах сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах;
- 3.4.2. Худалдан авах дулааны эрчим хүчний горим, төлөвлөлтийг оновчтой төлөвлөж оны эхэнд баталсан төлөвлөгөөг мөрдөх, холбогдох дүрэмд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ажиллах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан дулаан дамжуулах;
- 3.4.3. Дулаан дамжуулах сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж түүний хэвийн найдвартай ажиллагааг хангах, бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах;
- 3.4.4. Дулаан дамжуулах үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;
- 3.4.5. Дулаан дамжуулах сүлжээг төрийн өмчид шилжүүлэн авах арга хэмжээг зохион байгуулах, ашиглалт засвар үйлчилгээг хариуцан ажиллах;

- 3.4.6. Дулаан дамжуулах сүлжээнд шинээр холбогдсон барилга байгууламжуудын дулаан түгээх, хангах үйл ажиллагааг тухайн дамжуулах салаа шугамыг хариуцан ажиллаж буй дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх;
- 3.4.7. Дулаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангахад тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах;
- 3.4.8. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;
- 3.4.9. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах;
- 3.4.10. Санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах;
- 3.4.11. Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг бүрэн төвлөрүүлсэн байх;
- 3.4.12. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 3.4.13. Эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 3.5. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийн шаардлага:
- 3.5.1. Эрчим хүчний үйлдвэрлэл хангамжийг стандартын шаардлага болон хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн үр ашигтай диспетчерийн зохицуулалт хийж хэрэгжүүлсэн талаарх тайлан, дүгнэлтийг сар бүрийн 10-ны дотор ЭХЗХ-нд ирүүлэх;
- 3.5.2. Цахилгааны нэг худалдан авагчтай загвар, Спот зах зээл, Өрсөлдөөнт зах зээлийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, эдийн засгийн үр ашигтай горимыг бий болгоход хяналт тавьж ажиллах, холбогдох дүрэм журмыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж ЭХЗХ-оор батлуулж мөрдөж ажиллах;
- 3.5.3. Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хэрэглээг тэнцвэржүүлж, хангамж, хэрэглээний дунд болон урт хугацааны төлөвлөлтийг хийх;
- 3.5.4. Нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд эрчим хүчний хангамж хэрэглээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангах үүднээс цахилгаан, дулаан болон импорт, экспортын хэмжээг жилийн ± 2 хувиас илүүгүй өөрчлөлттэйгөөр төлөвлөх;
- 3.5.5. Нэгдсэн сүлжээ, төвлөрсөн дулаан хангамжийн системийг хамарсан аваар, саатлыг бүрэн бүртгэж хяналт тавих, тэдгээрийн шалтгаан нөхцөлд “Нэгдсэн сүлжээний дүрэм”-ийн дагуу оновчтой дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 3.5.6. Шинээр нэвтэрч буй техник технологийн шаардлагыг тусган Нэгдсэн сүлжээний дүрмийг олон улсын жишигт нийцсэн байдлаар шинэчлэн боловсруулж батлуулах, мөрдөж ажиллах;
- 3.5.7. Эрчим хүчний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтын дагуу Нэгдсэн сүлжээ, Төвлөрсөн дулаан хангамжийн нэгдмэл үйл ажиллагааг хангах горим тогтоож хянах, диспетчерийн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх;
- 3.5.8. Нэгдсэн сүлжээний дүрмийн 7.1-д заасны дагуу цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний техникийн алдагдлын норм, нормчлолыг тогтоох саналыг боловсруулан Төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, мөрдөж ажиллах;
- 3.5.9. Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд цахилгаан, дулааны хангамжийг таслах, хязгаарлах, сэргээх төлөвлөгөөг авч хэрэгжүүлэх;

3.5.10. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 10.2 дахь заалтад нийцүүлэн одоо ажиллаж байгаа цахилгаан станцуудаас жил бүр нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээг тусгаж, Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах;

3.5.11. Хуримтлуурын байгууламжийн нэгдсэн сүлжээнд нийлүүлэх энерги болон батарей хуримтлуурын системийг цэнэглэх үеийн горим зохицуулалтыг Төвийн бүсийн энерги балансад тусгасан хэмжээтэй уялдуулан байнгын хяналт тавьж үр ашигтай горим ажиллагааг хангаж хэрэгжүүлэх;

3.5.12. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;

3.5.13. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах;

3.5.14. Нэг худалдан авагчтай загварын авлага болон өглөгийг өсгөхгүй байх;

3.5.15. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.6. Цахилгаан түгээх тусгай зөвшөөрлийн шаардлага:

3.6.1. Цахилгаан түгээх сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангах, осол, аваар, сааталгүй ажиллах;

3.6.2. Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг дэд станц, шугам бүрээр, батлагдсан аргачлал болон тооцооны программ хангамжаар улирал, жилээр тооцоолох, техникийн болон арилжааны алдагдлыг бууруулах;

3.6.3. Цахилгаан түгээх сүлжээний ашиглалт засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийн ажлыг эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах;

3.6.4. Хэрэглэгчийн бага оврын тархмал эх үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ, чадлын дээд хязгаарыг жил бүр тооцож, ЭХЗХ-нд тайлагнах;

3.6.5. Цахилгаан түгээх сүлжээний хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангах зорилгоор иргэд, хуулийн этгээдэд шаардлага, хяналт тавих;

3.6.6. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;

3.6.7. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах;

3.6.8. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.6.9. Эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.7. Дулаан түгээх тусгай зөвшөөрлийн шаардлага:

3.7.1. Дулаан түгээх сүлжээний аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, осол, аваар, сааталгүй ажиллах, гарсан аваар, саатал, тасралтыг холбогдох дүрэм, журмын хүрээнд Диспетчерийн үндэсний төвд шуурхай мэдээлэх;

3.7.2. Худалдан авах дулааны эрчим хүчний хэмжээг оновчтой төлөвлөж, жилийн ± 2 хувиас хэтрүүлэхгүй байх, стандартын шаардлагад нийцсэн дулаан түгээх;

- 3.7.3. Дулаан түгээх сүлжээний засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийг эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрэмбэлэн төлөвлөж холбогдох дүрэм, журам, заавар, норм нормативын дагуу чанартай, үр дүнтэй бүрэн хийж гүйцэтгэх, үр ашиг, өгөөжийг тооцож тайлагнах;
- 3.7.4. Дулаан түгээх сүлжээний үйл ажиллагааг техник технологийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй, үр ашигтай явуулах;
- 3.7.5. Дулаан дамжуулах сүлжээг төрийн өмчид шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, ашиглалт засвар үйлчилгээг хариуцан ажиллах;
- 3.7.6. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад нийцээгүй барилга, байгууламжуудын дулаан түгээх үйл ажиллагааг тухайн ус, дулаан дамжуулах салаа шугамын хамгийн их ачаалалтай хэрэглэгчдийг хариуцан ажиллаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх, түүнээс шилжүүлэн авах, холбогдох хууль дүрэмд заасан дулаан дамжуулах сүлжээг дангаар хариуцан ажиллах;
- 3.7.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хариуцан ажиллаж буй ус, дулаан дамжуулах, түгээх сүлжээнээс холбогдсон хэрэглэгч (барилга байгууламж)-ийн дулаан түгээх сүлжээ, үйл ажиллагааг шилжүүлэн авахгүй байх;
- 3.7.8. Дулаан түгээх сүлжээний хамгаалалтын зурвасын хэвийн байдлыг хангах зорилгоор иргэд, хуулийн этгээдэд шаардлага, хяналт тавих;
- 3.7.9. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;
- 3.7.10. Батлагдсан тарифт тусгагдсан зардлыг үр ашигтай зарцуулж ажиллах;
- 3.7.11. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 3.7.12. Эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 3.8. Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн шаардлага:
- 3.8.1. Цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг оны эхэнд баталсан төлөвлөгөөнөөс ± 2 хувиас хэтрүүлэхгүй байх;
- 3.8.2. Хэрэглэгчийг стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр хангаж, цахилгаан тасалдлын индексийг өмнөх оноос бууруулах;
- 3.8.3. Хэрэглэгчдэд борлуулсан цахилгааны төлбөрийг бүрэн төвлөрүүлэх, цахилгаан худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдан авсан цахилгааны төлбөрийг бүрэн төлөх;
- 3.8.4. Хэрэглэгчдэд цахилгаан худалдахад урьдчилсан төлбөрт болон ухаалаг тоолуурын системийг жил бүр нэвтрүүлэх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх;
- 3.8.5. Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хангаж ажиллах, хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, бүрэн шийдвэрлэх;
- 3.8.6. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;
- 3.8.7. Татварын болон аудитлагдсан санхүүгийн тайлан, түүний тодруулгууд, холбогдох судалгаа, мэдээллийг үнэн зөв гаргаж хууль, дүрэм, журамд заасан болон шаардсан хугацаанд ирүүлэх, тайлагнах;
- 3.8.8. Санхүүгийн зохистой харьцааг хангаж цахилгаан эрчим хүчний өр, төлбөрийг өсгөхгүй байх;
- 3.8.9. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.9. Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн шаардлага:

3.9.1. Дулаан түгээх сүлжээний гидравлик тооцоог боловсруулж хангагчтай зөвшилцөх, стандартын шаардлагад нийцсэн дулаанаар хангах;

3.9.2. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад нийцээгүй барилга, байгууламжуудын дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагааг тухайн ус, дулаан дамжуулах салаа шугамын хамгийн их ачаалалтай хэрэглэгчдийг хариуцан ажиллаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх, түүнээс шилжүүлэн авах;

3.9.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хариуцан ажиллаж буй ус, дулаан дамжуулах, түгээх сүлжээнээс холбогдсон хэрэглэгч (барилга байгууламж)-ийн дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагааг шилжүүлэн авахгүй байх, маргаан үүсгэхгүй ажиллах;

3.9.4. Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хангаж ажиллах, хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, бүрэн шийдвэрлэх;

3.9.5. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны санхүүгийн тайлан бүртгэлийг бусад үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь бүртгэж, тайлагнах;

3.9.6. Хэрэглэгчдэд борлуулсан дулааны төлбөрийг бүрэн төвлөрүүлэх, дулаан худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдан авсан эрчим хүчний төлбөрийг бүрэн төлөх, "Дулааны нэг худалдан авагч"-тай загварыг мөрдөж ажиллах;

3.9.7. Татварын болон аудитлагдсан санхүүгийн тайлан, түүний тодруулгууд, холбогдох судалгаа, мэдээллийг үнэн зөв гаргаж хууль, дүрэм, журамд заасан болон шаардсан хугацаанд ирүүлэх, тайлагнах;

3.9.8. Санхүүгийн зохистой харьцааг хангаж дулааны эрчим хүчний өр, төлбөрийг өсгөхгүй байх;

3.9.9. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.10. Эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрлийн шаардлага:

3.10.1. ЭХЗХ-оос тогтоосон Эрчим хүчээр зохицуулалтгүй хангагдах хэрэглэгчийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх;

3.10.2. Хэрэглэгчид худалдах эрчим хүчний гэрээний үнийг тодорхойлж тус гэрээг ЭХЗХ-нд бүртгүүлэх;

3.10.3. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд ЭХЗХ-ноос тогтоосон хэрэглэгчдийг эрчим хүчээр найдвартай хангахад хүрэлцэх хэмжээний чадал, эрчим хүч авах талаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй тохиролцох;

3.10.4. Худалдан авсан эрчим хүчний төлбөрийг иргэн, хуулийн этгээдээр дамжуулахгүйгээр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид шууд төлөх;

3.10.5. Хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хангаж ажиллах, хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах, бүрэн шийдвэрлэх;

3.10.6. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.10.7. Эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.11. Цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрлийн шаардлага:

3.11.1. Цахилгаан импортлох, экспортлох зориулалттай шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, осол, аваар, сааталгүй ажиллах;

3.11.2. Цахилгаан импортлох, экспортлох шугам сүлжээний техникийн алдагдлыг дэд станц, шугам бүрээр батлагдсан аргачлал, тооцооны программ хангамж ашиглан улирал, жилээр тооцоолох, алдагдлыг

нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээг тогтмол авах, алдагдлыг бууруулах тооцоо, судалгаа төлөвлөгөөтэй ажилласнаар импортын алдагдлыг бууруулах;

3.11.3. Импорт, экспортын цахилгаан эрчим хүчний төлөвлөлтөд харьцуулан дүн, шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллах;

3.11.4. Цахилгаан импортлох, экспортлох, шугам сүлжээг өргөтгөх хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байх, шаардлагатай мэдээллээр хангах;

3.11.5. Цахилгаан импортлох, экспортлох шугамын хамгаалалтын зурвасын баталгаажуулалт хийлгэж, түүний хэвийн байдлыг хангуулах чиглэлээр тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран хангах нягт хамтарч ажиллах;

3.11.6. Импортлосон, экспортлосон цахилгаан эрчим хүчний төлбөрийг гэрээний дагуу сар бүр бүрэн төлөх;

3.11.7. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ЭХЗХ, Диспетчерийн үндэсний төвөөс цахилгаан импортлох нөхцөл, болзлын талаар Эрх бүхий байгууллагаас өгсөн удирдамж чиглэлийн дагуу цахилгаан импортлох, экспортлох гэрээ байгуулах, түүний хуулбар болон гэрээнд орсон өөрчлөлтийг тухай бүр ирүүлэх;

3.11.8. Татварын болон аудитлагдсан санхүүгийн тайлан, түүний тодруулгууд, холбогдох судалгаа, мэдээллийг үнэн зөв гаргаж хууль, дүрэм, журамд заасан болон шаардсан хугацаанд ирүүлэх, тайлагнах;

3.11.9. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.12. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн шаардлага:

3.12.1. Эрх бүхий байгууллагатай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулсан байх;

3.12.2. Тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 24 сарын дотор барилга байгууламжийг заасан хугацаанд барьж, ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх талаар хөрөнгө оруулагч талуудтай гэрээ эцэслэн байгуулсан байх;

3.12.3. “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм” болон холбогдох бусад дүрэм, журмын дагуу барилга байгууламжийн зураг төслийг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж, баталгаажуулах, магадлал хийлгэсэн байх; (Уламжлалт болон Усан цахилгаан станцийн хувьд)

3.12.4. “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн дагуу барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэсэн хувийг ирүүлэх;

3.12.5. Эрчим хүчний Төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлүүдтэй байх;

3.12.6. Барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах нөхцөл биелэгдсэнээс хойш холбогдох хууль журмын хүрээнд 12 сарын дотор эхлүүлсэн байх;

3.12.7. Эрчим хүчний барилга байгууламжийг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд барьж байгуулан, ашиглалтад оруулах;

3.12.8. Хяналт шалгалтын үр дүн, аудитын зөвлөмж, Хорооны шийдвэр, үүрэг даалгаврын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.12.9. Цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахаас өмнө сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барих хөрөнгө оруулалтын явцын тайлан, бодит гүйцэтгэл болон “Хамтарсан кредит олгох механизм”, “Цэвэр хөгжлийн механизм” зэрэг олон улсын хөнгөлөлтүүдийн орлоготой уялдуулан нэгдсэн

сүлжээнд нийлүүлэх тарифын саналыг барилга угсралтын ажил дууссаны дараа ирүүлэх;

3.12.10. Татварын болон аудитлагдсан санхүүгийн тайлан, түүний тодруулгууд, холбогдох судалгаа, мэдээллийг үнэн зөв гаргаж хууль, дүрэм, журамд заасан болон шаардсан хугацаанд ирүүлэх, тайлагнах.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг дүгнэх

- 4.1. Эрчим хүчний тухай хуулийн 12.1.1-12.1.11 дэх заалтад заасан тусгай зөвшөөрлийн шаардлагад хяналт тавих, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг сайжруулах, хэрэглэгчийн эрх ашгийг хангах зорилгоор тухайн жилийн шаардлага, түүний харгалзах оноог тогтооно.
- 4.2 Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор тусгай зөвшөөрлийн цахим системээр тайлагнах бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.
- 4.3. Тусгай зөвшөөрлийн тухайн жилийн шаардлагын биелэлтийг энэ дүрмийн 4.2-т заасан хугацаанд тайлагнаагүй тохиолдолд “Хангалтгүй” үнэлгээгээр дүгнэнэ.
- 4.4. Энэ дүрмийн 4.1-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагуудын биелэлтийг нийт дүнг дараах үнэлгээгээр дүгнэх бөгөөд үйл ажиллагааны үндсэн хүчин зүйлийн бодит өөрчлөлтийг харгалзан үзнэ.

Биелэлтийн оноо (%)	Үнэлгээ
90-ээс 100 хүртэл	Хангалттай сайн
75-аас 90 хүртэл	Сайн
60-аас 75 хүртэл	Дунд
60 хүртэл	Хангалтгүй

- 4.5. Өөрийн хэрэгцээг хангах зориулалттай цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах үед тогтоосон тусгай зөвшөөрлийн шаардлагуудын арифметик дунджаар биелэлтийг тооцож энэ дүрмийн 4.4-т заасан үнэлгээгээр дүгнэнэ.
- 4.6. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн шаардлагыг арифметик дунджаар дүгнэх бөгөөд биелэлтийн хугацаа нь хүрээгүй шаардлагуудыг хасаж тооцно.
- 4.7. Тусгай зөвшөөрлийн шаардлагын тухайн оны биелэлтийг Эрчим хүчний зохицуулах хорооны хурлаар хэлэлцэн дүгнэж, дараа жилд мөрдөх шаардлагын хамт тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.